

Есүс Христээр дамжин ирдэг сонгох эрх ба гэтэлгэл

Чөтгөрийн уруу таталтууд

Сургаал ба Гэрээ 29:39 болон 2 Нифай 2:16–18-ыг уншаад, дараах асуултуудын талаар ярилц.

- Бид энэ амьдралаас өмнө Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар сонгосон гэдгээ мэддэг ч энэ дэлхий дээр Түүнийг үргэлж дагахыг сонгоход юу нь хэцүү байдаг вэ?
- Дэлхий дээр байгаа хүмүүсийг Бурханы зөвлөгөөг дагахгүй байхыг сонгоход хүргэдэг Сатаны хамгийн үр дүнтэй арга юу вэ?
- Сатаны уруу таталтыг даван гарахад туслах ямар адислалуудыг Бурхан бидэнд өгсөн бэ?

Бидний сонголтын үр дагавар

Сургаал ба Гэрээ 29:40–41, Алма 41:10–11; 42:9, 14-ийг уншаад, дараах асуултуудын талаар ярилц.

- Бид Бурханыг эсэргүүцэхийг сонгох үедээ чөтгөрийн таалалд ямар байдлаар захирагддаг вэ?
- “Сүнсний үхэл” хэмээх нэршил нь яагаад Тэнгэрлэг Эцэгээс тусгаарлагдах гэдэг ойлголтын сайн тайлбар юм гэж та бодож байна вэ?
- Бидний Тэнгэрлэг Эцэгийн хүслийн эсрэг сонгох эрхээ ашигласны дараа мэдэрдэг мэдрэмжийг та хэрхэн дүрслэх вэ?

Бурханы Төрсөн Ганц Хүүгээр дамжин ирэх гэтэлгэл

Сургаал ба Гэрээ 29:42–43 болон 2 Нифай 2:6–9-ийг уншаад, дараах асуултуудыг авч ярилц.

- Биднийг тааруу сонголт хийсний дараа ч гэтэлгэлийг боломжтой болгохын тулд Есүс Христ юу хийсэн бэ?
- Аль хэдийн хэт холдсон гэж мэдэрч буй хэн нэгэнд найдвар төрүүлэх Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай та юу хуваалцах байсан бэ?
- Та Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын гэтэлгэх, уучлах мөн чанарыг харуулах ямар жишээг хуваалцаж болох вэ?